


Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны  
2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн  
34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ


Компанийн нэр: "Хүрд" ХК  
Хаяг, утас: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 6-р хороо,  
Сүхбаатарын гудамж-71, Компанийн байр.  
Утас: 325130, 99012597, 99096490  
Хурал хуралдах огноо, цаг, газар: 2015 оны 04 сарын 10-ны өдөр. 16.00.цаг  
компанийн байранд  
Хурал хуралдах шийдвэр  
гаргасан огноо: 2015 оны 02 сарын 02 өдөр  
Олон нийтэд зарлах огноо 2015 оны 02 сарын 06 өдөр  
Бүртгэх өдөр 2015 оны 02 сарын 16 өдөр  
Гэрээний дагуу хурлын баримт,  
бичгийг брокер дилерийн  
компанид хүргүүлэх огноо .....  
Хурлын баримт, бичгийн хуудсын тоо ..... ширхэг, хуудас .....

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

КОМИССЫН ДАРГА:  /Б.БАТ-ЭРДЭНЭ/

2015 оны 02 дугаар сарын 04-ний өдөр

ХҮЛЭЭН АВСАН:

МХБирж БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН:  .....

/...../ 2015 оны ..... дүгээр сарын ..... өдөр

СЗХороо БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН: .....

/...../ 2015 оны 2... дүгээр сарын 2... өдөр



## “ХҮРД” КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 02-р сарын 02-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г 7  
Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналыг үндэслэн  
ТОГТООХ НЬ :

Нэг. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 04-р  
сарын 10-ны өдрийн 16.00 цагт компанийн байранд хуралдуулсугай.

Хоёр. Хурал зохион байгуулах болон хурлын тооллогын комиссыг  
дараахь бүрэлдэхүүнтэй ажиллуулсугай.

Үүнд: Б.Бат-Эрдэнэ  
Г.Гантуяа  
Ж.Дүгэржав

Гурав. Хурлаар дараахь асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан танилцуулж батлах
2. Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг  
хэлэлцэж батлах
3. Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах
4. Бусад

ТУЗ-ийн дарга

Б.Мөнхбат



## Хүрд ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

"Хүрд" (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04-р сарын 10-ны өдрийн 16:00 цагт УБ хот Чингэлтэй дүүрэг, 6-р хороо Сүхбаатарын гудамж-71, өөрийн байранд болох тул хуралдаа хүрэлцэн ирнэ үү.

Хурлаар дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан танилцуулж батлах
2. Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах
4. Бусад

Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь:

2015 оны 02-р сарын 16-ны өдөр байна.

Хурлын талаар мэдээллийг компанийн байранд ирж буюу дараахь утсаар авна уу.

Утас: 320935, 325130, 99012597, 99096490

Хурал Зохион Байгуулах Комисс

Хурлаар хэлэлцэх асуудлын  
бэлэн болох хугацаа: -

11. "Хүрд" компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан- 2015 оны  
02-р сарын 27

2. "Хүрд" компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн  
дүгнэлт- 2015 оны 02-р сарын 27

3. "Хүрд" компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардал-  
2015 оны 02-р сарын 27





## “ХҮРД” КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 02-р сарын 02-ны өдөр

Дугаар .02

Улаанбаатар хот

Г

Г

*Саналын хуудасны агуулга, загвар батлах тухай*

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналыг үндэслэн  
ТОГТООХ НЬ :

Нэг. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2014 оны ээлжит хурлын саналын  
хуудасны агуулга, загварыг хавсралтын дагуу баталсугай.

ТУЗ-ийн дарга

Б.Мөнхбат



Санал авах хуудас

"Хүрд" /ХК/ компани

Компанийн  
Тамга



Хувьцаа эзэмшигч.....овогтой.....  
Регистрийн дугаар.....  
Эзэмшиж буй хувьцааны:  
-Төрөл ...../энгийн,давуу/ -Тоо.....

Ердийн журмаар өгөх саналын тоо.....

Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2015 оны 04 сарын 10-ны өдрийн 16.00 цагт компанийн байранд болно.

Та сонгосон санал дээрээ өөрийн эзэмшдэг хувьцааны тоог тавина уу.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Санал хураах аргын нэр
1	Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах				Ердийн /хувьцааны тоо тавих/
2	Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах				Ердийн
3	Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах				Ердийн
4	Бусад				Ердийн

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг ...../ /

Санал авах хуудсыг үйлдсэн 2015 оны 04-р сарын 10-ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга...../ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:.....

Тооллогын комиссын дарга...../ /



## "ХҮРД" (ХК) КОМПАНИ

Монгол улс, Улаанбаатар хот-46,  
Сүхбаатарын гудамж-71  
Утас: 320697, 325130 Факс: 976-11-320697  
E-mail: khurdcompany@gmail.com

Танай \_\_\_\_\_ № \_\_\_\_\_  
-ны № \_\_\_\_\_ -т

г Зар нийтлүүлэх тухай г

г "ӨДРИЙН СОНИН"-Ы ГАЗАРТ г

Манай компанийн хүсэлтээр доорхи зарыг 2015 оны 02-р сарын 06-ны өдрийн дугаарт нийтэлж өгнө үү. Үүнд:

### Хүрд ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

"Хүрд" (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04-р сарын 10-ны өдрийн 16:00 цагт УБ хот Чингэлтэй дүүрэг, 6-р хороо Сүхбаатарын гудамж-71, өөрийн байранд болох тул хуралдаа хүрэлцэн ирнэ үү.

Хурлаар дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан танилцуулж батлах
2. Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах
4. Бусад

Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь: 2015 оны 02-р сарын 16-ны өдөр байна.

Хурлын талаар мэдээллийг компанийн байранд ирж буюу дараахь утсаар авна уу.

Утас: 320935, 325130, 99012597, 99096490

Хурал Зохион Байгуулах  
Комисс

Та бүхнийг хүндэтгэсэн.

Ерөнхий Захирал

Б. Энхжаргал





## "ХҮРД" (ХК) КОМПАНИ

Монгол улс, Улаанбаатар хот-46,  
Сүхбаатарын гудамж-71  
Утас: 320697, 325130 Факс: 976-11-320697  
E-mail: khurdcompany@gmail.com

Танай \_\_\_\_\_ № \_\_\_\_\_  
-ны № \_\_\_\_\_ -т

Зар нийтлүүлэх тухай

## "ҮНДЭСНИЙ ШУУДАН" СОНИНЫ ГАЗАРТ

Манай компанийн хүсэлтээр доорхи зарыг 2015 оны 02-р сарын 06-ны өдрийн дугаарт нийтэлж өгнө үү. Үүнд:

### Хүрд ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

"Хүрд" (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04-р сарын 10-ны өдрийн 16:00 цагт УБ хот Чингэлтэй дүүрэг, 6-р хороо Сүхбаатарын гудамж-71, өөрийн байранд болох тул хуралдаа хүрэлцэн ирнэ үү.

Хурлаар дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан танилцуулж батлах
2. Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах
4. Бусад

Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь: 2015 оны 02-р сарын 16-ны өдөр байна.

Хурлын талаар мэдээллийг компанийн байранд ирж буюу дараахь утсаар авна уу.

Утас: 320935, 325130, 99012597, 99096490

Хурал Зохион Байгуулах  
Комисс

Та бүхнийг хүндэтгэсэн:

Ерөнхий Захирал

Б. Энхжаргал



**ХҮРД ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

"Хүрд" (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04-р сарын 10-ны өдрийн 16:00 цагт УБ хот Чингэлтэй дүүрэг, 6-р хороо Сүхбаатарын гудамж-71, өөрийн байранд болох тул хуралдаа хүрэлцэн ирнэ үү.

Хурлаар дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан танилцуулж батлах
2. Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах
4. Бусад

Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь: 2015 оны 02-р сарын 16-ны өдөр байна.

Хурлын талаар мэдээллийг компанийн байранд ирж буюу дараахь утсаар авна уу.

Утас: 320935, 325130, 99012597, 99096490

Хурал Зохион Байгуулах Комисс

**ХҮРД ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

"Хүрд" (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04-р сарын 10-ны өдрийн 16:00 цагт УБ хот Чингэлтэй дүүрэг, 6-р хороо Сүхбаатарын гудамж-71, өөрийн байранд болох тул хуралдаа хүрэлцэн ирнэ үү.

Хурлаар дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан танилцуулж батлах
2. Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах
4. Бусад

Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь: 2015 оны 02-р сарын 16-ны өдөр байна.

Хурлын талаар мэдээллийг компанийн байранд ирж буюу дараахь утсаар авна уу.

Утас: 320935, 325130, 99012597, 99096490

Хурал Зохион Байгуулах Комисс

## "Хүрд" ХК-ийн хувьцаа ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛ

"Хүрд" (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны дөрөвдүгээр сарын 10-ны өдрийн 16.00 цагт Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо Сүхбаатарын гудамж-71, өөрийн байранд болох тул хуралдаа хүрэлцэн ирнэ үү.

**Хурлаар дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:**

- 1.Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан танилцуулж батлах
- 2.Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
- 3.Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах
- 4.Бусад

Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр 2015 оны хоёрдугаар сарын 16.

Хурлын талаар мэдээллийг компанийн байранд ирж буюу дараахь утсаар авна уу.

**Утас: 320935, 325130, 99012597,  
99096490**

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

## "Хүрд" ХК-ийн хувьцаа ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛ

"Хүрд" (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны дөрөвдүгээр сарын 10-ны өдрийн 16.00 цагт Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо Сүхбаатарын гудамж-71, өөрийн байранд болох тул хуралдаа хүрэлцэн ирнэ үү.

**Хурлаар дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:**

- 1.Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан танилцуулж батлах
- 2.Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
- 3.Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах
- 4.Бусад

Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр 2015 оны хоёрдугаар сарын 16.

Хурлын талаар мэдээллийг компанийн байранд ирж буюу дараахь утсаар авна уу.

**Утас: 320935, 325130, 99012597.**



## Хүрд ХК-ийн 2014 оны санхүүгийн тайлангийн хураангуй

Баланс	/мян.төг/ Аудитлагдсан
Мөнгө түүнтэй адилгах хөрөнгө	4,454,434.2
Дансны авлага	854,261.9
Бараа материал	783,326.9
Бусад эргэлтийн хөрөнгө	246,154.5
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	11,092.0
Үндсэн хөрөнгө	575,183.2
Биет бус хөрөнгө	1,050.0
Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	214,921.0
Бусад эргэлтийн бус хөрөнгө	102,897.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,243,321.3</b>

Богино хугацаат өр төлбөр	
Дансны өглөг	425,801.9
Татварын өр	113,228.3
Ногдол ашгийн өглөг	5,079.9
Урьдчилж орсон орлого	3,657,893.9
Бусад богино хугацаат өр төлбөр	4,218.3

Урт хугацаат өр төлбөр	/мян.төг/ Аудитлагдсан
Хувийн өмч	463,797.8
Эздийн өмчийн бусад хэсэг	
Хуримтлагдсан ашиг	2,573,301.2

### Орлогын тайлан

Борлуулалтын орлого	7,291,093.8
Борлуулалтын өртөг	6,870,261.1
<b>Нийт ашиг (адлагдал)</b>	<b>420,832.7</b>
Түрээс, бусад орлого	361,183.6
Ерөнхий ба удирдлагын болон бусад зардал	372,589.3
Үндсэн үйл ажиллагааны ашиг	409,427.0
Татварын дараах ашиг	368,484.3

### Өмчийн өөрчлөлтийн тайлан

Өмчийн эхний үлдэгдэл	2,702,836.9
Нэмэгдсэн өөрчлөлт	368,484.3
Хасагдсан өөрчлөлт	
Өмчийн эцсийн үлдэгдэл	3,071,321.2

"Хүрд" /ХК/ компани

18

2015.03.10 МЯГМАР №057 (5009)





ҮНЭТ ЦААСНЫ  
ТӨЛБӨР, ТООЦОО ТӨВЛӨРСӨН  
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Самбуугийн гудамж 16/1 тоот, Утас/Факс: (976) 7011-4424

2015.03.03 № 01/874  
танай 2015.02.26-ны № 45 -т

“ХҮРД” ХК-д

Танайхаас ирүүлсэн 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 45 тоот албан бичгийн дагуу “Хүрд” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, хавсралтаар хүргүүлэв.

Хавсралтанд:

1. Үнэт цаас эзэмшигчдийн судалгаа / 8 хуудас/

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Ш.ЛХАГВА* Ш.ЛХАГВА



“ХҮРД” /ХК/ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДЭГ

2015-04-10

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг Тооллогын комиссоос авч гишүүдэд мэдээлж Хурлын удирдлага, Хурлын нарийн бичгийн даргыг томилох. /ХЗБКомисс/
2. Хурлын ирц мэдээлэгдсэнээс хойш хурлын явцад хуралд ирэгсдийг бүртгэн авч саналын хуудас олгохгүй.
3. Хэлэлцэх асуудлын талаарх ТУЗ-ийн мэдээлэл, дүгнэлтийг танилцуулна. /Хурлын дарга/
4. Гаргах шийдвэрийн талаар хэлэлцэх. Хүн бүр 5 минут.
5. Хурлыг 16:00 цагт эхэлнэ. Хурал 1 цаг үргэлжлээд 10 минут завсарлана. Хурлыг 1 цаг 30 минутад багтаана.
6. Хуралд оролцогсдын 75-с дээш хувийн саналаар хурлын цагийг сунгаж болно.
7. Тооллогын комисс саналын хуудсыг хүлээн авна.
8. Санал хураалтын дүнг шийдвэр бүрээр гаргаж хуралд танилцуулна.
9. Санал хураалтын дүнг үндэслэн хурлаас гарах шийдвэрийг танилцуулна.
10. Хурлын дарга үг хэлж хурлыг хаана.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС


Хувь нийлүүлэгчдийн Хурлын ирцийн тухай  
Мэдээлэл

Улаанбаатар хот


2015.04.10

“Хүрд” ХК-нь саналын эрх бүхий 135266 ширхэг хувьцаатайгаас өнөөдрийн хуралд саналын эрхтэй 125895 ширхэг хувьцаа эзэмшдэг 11 хувь нийлүүлэгчид хүрэлцэн ирснээр ирцийн хувь **93.1** % болж байна.

Хурлын ирц нь Компанийн тухай хуулийн 69.1-д “Саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.” гэж заасныг бүрэн хангаж байна.

Тооллогын комиссын дарга:  Ж.Дүгэржав

Гишүүн:  Г.Гантуяа

 О.Шинэхүү




"Хүрд" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04 сарын 10-ний  
өдрийн хурлын ирц /Кворум/

д/д	Овог нэр	Ирсэн эсэх	Регистрийн дугаар	Эзэмшиж буй хувьцааны тоо
1	Бүлтэнхүү Энхжаргал		УШ 55111911	94494
2	Долгор Дашдорж		ХА 45051814	1140
3	Бүтээ Эрдэнэ		УК 42082678	1220
4	Содном Эрдэнэчимэг		УШ 62051129	15539
5	Цэцэнжаргал Эрдэнэсүх		ХИ 55070872	4636
6	Бүлтэнхүү Мөнхбат		ОЛ 67082377	4229
7	Гаанжуур Алтансүх		ПЭ 81031711	251
8	Давид Мадгаа		ЦЗ47070118	2096
9	Бавуу Лундаа		ЧЛ55092018	421
10	Лхам Цэрэндондог		ХЖ32070170	200
11	Лувсан Оюунтогтох		ЧВ41070371	1669
12				
13				
14				
15				
16				
17				
18				
19				
20				
	Дүн			<b>125895</b>

Нийт хувьцааны тоо: 135266

Ирцийн хувь: **93.1 %**

Ирц бүртгэсэн..... Г.Гантуяа

**“ХҮРД” /ХК/ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 10

Дугаар 01

Улаанбаатар хот

“Хүрд” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04-р сарын 10-ны өдрийн хурлын Тооллогын комиссын хурлаас ТОГТООХ НЬ:

1. Хуралд саналын эрх бүхий 135266 ширхэг хувьцаатайгаас саналын эрхтэй 125895 ширхэг хувьцаа эзэмшдэг 11 хувь нийлүүлэгч хүрэлцэн ирснээр ирцийн хувь 93.1 % болж, Компанийн тухай хуулийн 69.1-д "Саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно" гэж заасныг бүрэн хангаж байгаа тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулсугай.

Тооллогын комиссын дарга:..... Ж.Дүгэржав

Гишүүн:..... Г.Гантуяа

..... О.Шинэхүү

Хүрд ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
2015.04.10-ны өдрийн хурлын тэмдэглэл

Хурал 2015.04.10-ны өдрийн 16.00 цагт компанийн хурлын заланд болов. Хуралд нийт 125895 ширхэг саналын эрх бүхий 11 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирснээр хурлын ирц 93,1% болсон талаар тооллогын комисс танилцуулав.

Хуралд Б.Энхжаргал, Д.Дашдорж, Б.Эрдэнээ, Д.Мадгаа, Б.Мөнхбат, С.Эрдэнэчимэг, Ц.Эрдэнэсүх, Г.Алтансүх, Б.Лундаа, Л.Цэрэндондог, Л.Оюунтогтох нарын 11 хувьцаа эзэмшигч оролцлоо.

Хурлын дэгийг танилцуулсны дараа хурлын даргаар Б.Мөнхбат, хурлын нарийн бичгийн даргаар Г.Гантуяа нарыг 100 хувийн саналаар сонгов.

Хурлын дарга Б.Мөнхбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд:

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах
2. Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө батлах. Бизнес төлөвлөгөөний хүрээнд Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт цэцэрлэг бүхий 98 айлын орон сууц барих зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцэж батлах
4. Компанийн 2015 оны удирдлагын зардлыг батлах
5. Компанийн 30 машины гаражийн барилгыг ашиглалтаас хасах ТУЗ-ийн тогтоолыг батлах
5. Компанийн боловсон хүчин бэлтгэх зардлыг олгосон ТУЗ-ийн тогтоолыг батлах.

Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хурлын дарга Б.Мөнхбат уншиж танилцуулав.

Мөн компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардал, бизнес төлөвлөгөөний дагуу Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт цэцэрлэг бүхий 98 айлын орон сууц барих, компанийн 30 машины гаражийн барилгыг ашиглалтаас хасах, компанийн боловсон хүчин бэлтгэх зардлыг олгосон ТУЗ-ийн тогтоолыг батлах талаар танилцуулав.

Компанийн тайлан, бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг танилцуулсны дараа хувьцаа эзэмшигчид санал бодлоо илэрхийлж ярилцав.



**Д.Дашдорж** -Компанийн 2014 оны үйл ажиллагааны талаар ТУЗ-ийн тайланг сонслоо. Бизнес төлөвлөгөө тоо хэмжээний хувьд давж биелжээ. Ашгийн хэмжээ, дундаж цалин өссөн байна. Хийгдсэн ажлын үр дүнгээр удирдлагын урамшууллыг олгожээ. Удирдлагын зардлыг хэмнэсэн байна. Ашиглалтгүй байсан тоног төхөөрөмж, машин механизмыг ашиглалтаас хасч, зарж борлуулсан байна.

Компанийн ирээдүйн боловсон хүчин бэлтгэж эхэлсэн нь сайн байна. Үүнийг цааш нь үргэлжлүүлж, одоо ажиллаж байгаа ИТА болон ажилчдаа сургалтанд хамруулах шаардлагатай.

Автобааз, хангамж алдагдалтай ажиллажээ. Мөнгөн хөрөнгө банкинд байршуулж, 252,0 сая төгрөгийн хүүгийн орлого олсон боловч санхүүгийн бичилтээс хамаарч 59,76 сая төгрөгийн алданги төлжээ.

Барилга угсралтын ажлыг гүйцэтгээд олж авч чадаагүй байгаа 3,6 тэрбум төгрөгийг олж авах талаар арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байгаа юм байна. Орон сууц барих асуудлыг дэмжиж байна. Өөрийн нөөц бололцоогоо ашиглан, банкны зээл бага хэмжээгээр авч богино хугацаанд барих шаардлагатай. Борлуулалтын асуудлыг анхаарч захиалагчдаас хөрөнгө босгох ажлыг зохион байгуулах.

Компанийн бизнес төлөвлөгөөг батлах саналтай байна.

Нарлаг зочид буудал, хангамж, автобаазын алдагдалтай ажилласныг анхаарах.

Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

**Б.Эрдэнээ**-ТУЗ-өөс оруулж байгаа 2014 оны үйл ажиллагааны тайланг сонслоо. Татварын шалгалт байсаар л байна. Ямар нэг алдаа илрүүлж, мөнгө нэхэж дарамталдаг. Алдаа тус бүрийг дахин давтагдахгүйгээр арга хэмжээ авч төлөвлөгөө болосруулж ажиллах. Ингээгүйгээс үргүй зардал гарч байна.

Компанийн гүйцэтгэсэн бүх ажлыг сайн тайлагнаж тусгасан байна. Инфляцийн түвшингээс хамаарч удирдлагын зардлыг өсгөж тооцсон байна. Компани бол нийгэм дэх үйл ажиллагааны тусгал юм. Нийгэмд эдийн засгийн хямрал болж, үйл ажиллагаа хямарч байна. Энэ компанид ийм юм алга. Хяналт шалгалт сайн байна. Анхан шатны бүртгэлийг шат шатандаа хариуцлагатай хөтөлж явбал үр дүн сайтай байна. Санхүү энэ тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод борлуулалтгүй 30000 орон сууц байна. Ийм нөхцөлд орон сууцны барилга барих хэцүү асуудал. Тэгэхдээ энэ орон сууцыг барихад хотын төвд, инженерийн шугам сүлжээнд ойр, газар худалдаж авахгүй зэрэг давуу талууд бий. Тиймээс богино хугацаанд чанартай барьж, боломжийн үнээр борлуулах тал дээр анхаарч ажиллах.

ТУЗ-ийн тайланг батлах саналтай байна.



**Г.Алтансүх-** Барих гэж байгаа орон сууцны талаар тодруулмаар байна. Бүрэн цутгамал уу.

**Л.Цэрэндондог-** Орон сууцны нийт өртөг 6,45 тэрбум төгрөг болж байгаа юм байна. Хөрөнгөө яаж босгох вэ.

**Б.Мөнхбат-** Каркастай орон сууц. Захиалагч инженер Адилбиш та орон сууцны талаар танилцуулна уу. Мөн энд танилцуулга байгаа.

**М.Адилбиш-** Баянзүрх дүүрэгт барих орон сууц маань 1 давхартаа 7 айлтай. Орон сууцны 1 давхарт хүүхдийн цэцэрлэгтэй. Зоорийн давхар, 51 машины гаражтай. Урьдчилсан тооцоогоор 6,45 тэрбум төгрөгөөр төлөвлөж байна. Үүний 4 тэрбум төгрөгийг компани , 2,45 тэрбум төгрөгийг банкны зээл, байр захиалагчийн хөрөнгө, хамтран ажиллагсдын хөрөнгөөр санхүүжүүлнэ.

3 өрөө-28 ширхэг, 2 өрөө -56 ширхэг, 1 өрөө-14 ширхэг орон сууцнууд бий. Орчны тохижилт автозам сайтай. Гадна талбай сайтай. Оршин суугчдын 50% нь битүү дулаан зогсоолоор хангагдана. Цутгалтын ажил гүйцэтгүүлэхээр 14 компанид урилга хүргүүлсэн байгаа.

**Л.Цэрэндондог-** ТУЗ-ийн илтгэл сонслоо. Ашиг орлого нэмэгдэж, ажилчдын цалин өссөн байна. Санхүүгийн акт тавиулахгүй байх тал дээр анхаарч ажиллах. Шинэ материал, техник технологи нэвтрүүлж ажиллах

Орон сууц барих хөрөнгийн асуудлыг зөв шийдвэрлэж ажиллахыг анхааруулж байна.

**Б.Энхжаргал-**Шинээр барих орон сууцны танилцуулга, 2014 оны санхүүгийн баланс, 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлын тооцоо ширээн дээр тавигдсан байгаа. Та бүхэн танилцаарай. Хэлэлцэж байгаа асуудлын талаар тайлбар өгье. Манай компани Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжсэн барилгуудад ажилласан.Энэ барилгууд нь НӨАТ-аас чөлөөлөгдсөн. Эдгээр барилгуудад материалын НӨАТ давхар тооцогдсон байсан. Мөн он дамжиж санхүүжсэн барилгуудын санхүүжилт байна. Татварын албанаас орж ирсэн даруйд нь борлуулалт болго гэдэг шаардлага тавьсан.Гэтэл барилга угсралтын ажлын баталгаа 3 жил байдаг. Иймээс бүх борлуулалтыг тэр дор нь борлуулах арга байхгүй. Энэ хоёр асуудалд акт тавигдсан. Авлага өглөгт дүн шинжилгээ хийж ажиллана. Барилга угсралтын ажлын санхүүжилт олж авах тал дээр анхаарч ажиллана. Барилга угсралтын ажлыг нь гүйцэтгэж дуусаад ашиглагч байхгүйгээс ажиллуулж хүлээлгэж өгөөгүй объектууд байна. Дэнжийн 1000-ын гадна дулааны шугам 2 ажил, Орбитын цэвэр усны шугам 8 жил болж байна. Орон сууц барих төлөвлөгөөтэй. Нийт 6,45 тэрбум төгрөгийн хөрөнгө шаардлагатай. 2015 онд компани 2,5 тэрбум, 2016 онд 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө гаргах хуримтлал байна. Үлдсэн хөрөнгийг бусад эх үүсвэр-банкны зээл, худалдан авагчийн хөрөнгө, бусад хамтрагчдын хөрөнгөөр санхүүжүүлнэ. Банкны зээлийг бага хүүтэй, богино хугацаанд авах, бартерээр санхүүжих гэх мэт. Орон сууцны талбай -1900м2, орон сууцны талбайгаас тал тал тийшээ 12,12 м тэлж гараж барина.Борлуулах үнэ, олох ашгийн тооцоо хийнэ.



Улаанбаатар хотод 2014 онд барьсан 8000 орон сууц, 2015 онд 20000 орон сууц ашиглалтанд орно гэсэн мэдээ байна. Тиймээс орон сууц борлуулах зах зээлээ судална. Та бүхнийг ч орон сууцны борлуулалтанд анхаарлаа хандуулахыг хүсч байна. Бартерээр ажиллах компаниудтай хамтарна. Хамтран ажиллах санал их ирж байна. 30% урьдчилгаа аваад материал нийлүүлэх, 2016-2017 онд үлдсэн мөнгөө авах санал ирж байна.

Борлуулалтын өртгийг өндөр тавихгүй. Өнөөдрийн зах зээлийн ханшийг судална.

Компанийн үйл ажиллагаа уламжлалт аргаараа явж байна. Компанийн хашаанд цогцоор нь орон сууц барих төлөвлөгөө байна. Үүнд 30-40 тэрбум төгрөгийн хөрөнгө шаардлагатай байна.

ТУЗ-ийн тайланд эдийн засгийн үзүүлэлтийг тусгаж өгсөн. Энэ компани хэдэн төгрөгийн зээлтэй, ашигтай ажилласан эсэх, хөрөнгө бүрэн эсэхийг хувьцаа эзэмшигчид сонирхдог. Нэгж хувьцаанд 273 төгрөг, нийт 36,9 сая төгрөг олгохоор шийдвэрлэсэн байгаа. Энэ нь цэвэр ашгийн 10% болж байгаа. Үлдсэн ашгийг компани хөгжүүлэх, боловсон хүчин бэлтгэх, орон сууц барих зэрэгт зарцуулна.

Та бүхэн бизнес төлөвлөгөө болон хэлэлцсэн асуудалд саналаа өгнө үү.

**С.Эрдэнэчимэг**-Нарлаг зочид буудал ашигтай ажиллана гэдэг хэцүү байна. Одоо эдийн засгийн хямрал болоод буудалд ордог хүмүүсийн тоо эрс багассан. Үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх саналтай байна.

**Г.Алтансүх** - Зочид буудлын барилгад засвар хийж, гадна үзэмжийг сайжруулбал ямар вэ.

**Б.Энхжаргал**- Нарлаг зочид буудал сард 8,0 сая төгрөгийн орлого олж байж зардлаа нөхнө. Гэтэл буудлын 50% нь ашиглалтгүй байна. Гал тогоо, бильярд гээд. Нийт 18 өрөөний 3-4 нь л ашиглалттай байна.

**С.Эрдэнэчимэг** - Гадуур явж ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг газруудын талаар судалгаа хийж үзлээ. Эдийн засгийн хямрал нөлөөлж байна. Аль ч буудал үйлчлүүлэгчгүй болсон байна.

**Д.Дашорж**- Буудлын үйл ажиллагааны талаар гадны байгууллагын дүгнэлт гаргуулах хэрэгтэй. Үйл ажиллагааны чиглэлийг өөрчиллөө гэдэг ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулах талаар судалгаа хийх.

**Б.Энхжаргал**- Хуралд бидний оруулсан орон сууц барих, гаражийн барилгыг ашиглалтаас хасах асуудлыг дэмжиж саналаа өгөхийг хүсч байна.

Мөн компанийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шинэ техник технологи оруулж ирэх талаар санал оруулж буй нөхдөд баярлалаа. Эдийн засгийн чиглэл, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр удирдах түвшний хүн бэлтгэх талаар бодлого боловсруулж, зардлыг тооцож хуралд оруулах нь зүйтэй гэж бодож байна.

**Д.Мадгаа**- Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад ТУЗ-ийн дүгнэлтийг батлах саналтай байна. Мөн санхүүгийн тайланг мөн батлах саналтай байна.



Хувьцаа эзэмшигчдийн санал шүүмжлэлийг сонссоны дараа компанийн 2014 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, 2015 оны бизнес төлөвлөгөө, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт цэцэрлэг бүхий 98 айлын орон сууц барих зөвшөөрөл олгох , 2015 оны удирдлагын зардал, компанийн 30 машины гаражийн барилгыг ашиглалтаас хасах ТУЗ-ийн тогтоолыг батлах, боловсон хүчин бэлтгэх зардлыг олгосон ТУЗ-ийн тогтоолыг батлах санал хураалт явагдаж, 100 хувийн саналаар тус тус батлагдлаа.

Хурлыг хааж, хурлын дарга Б.Мөнхбат үг хэлснээр 17.25 цагт хурал дуусав.

Протокол хөтөлсөн:

Хурлын нарийн бичгийн дарга



Г.Гантуяа

**“ХҮРД” /ХК/ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 10

Дугаар 02

Улаанбаатар хот

“Хүрд” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04-р сарын 10-ны өдрийн хурлын Тооллогын комиссын хурлаас ТОГТООХ НЬ:

Хуралд оролцсон саналын эрхтэй 125895 ширхэг хувьцаа эзэмшдэг 11 хувь нийлүүлэгчийн саналын хуудсын үндэслэн хуралд хэлэлцсэн доорх асуудал тус бүрээр саналын тоог хувьцаа эзэмшигчдийн хуралд илтгэсүгэй. Үүнд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж баталсан 125895 саналын тоо 100 %.

2. Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж баталсан 125895 саналын тоо 100 %.


3.1. Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө хэлэлцэж баталсан 125895 саналын тоо 100 %.

3.2. Баянзүрх дүүрэгт цэцэрлэг бүхий 15 давхар 98 айлын орон сууц барих зөвцөөрөл олгосон 125895 саналын тоо 100 %.

4. Компанийн удирдлагын зардлыг хэлэлцэж баталсан 125895 саналын тоо 100 %.

5. Компанийн 30 машины гараж барилгыг ашиглалтаас хасах ТУЗ-ийн тогтоолыг баталсан 125895 саналын тоо 100 %.

6. Компанийн боловсон хүчин бэлтгэх зардлыг олгосон ТУЗ-ийн тогтоолыг баталсан 125895 саналын тоо 100 %.

Тооллогын комиссын дарга:  Ж.Дүгэржав

Гишүүн:  Г.Гантуяа

 О.Шинэхүү



## “ХҮРД” /ХК/ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04-р сарын 10-ны өдөр

Дугаар ...01

Улаанбаатар хот

Г

Г

Компанийн 2014 оны үйл ажиллагаа, санхүүгийн  
тайланг дүгнэж, батлах тухай

“Хүрд” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04 -р сарын 10-ны өдрийн хурлын Тооллогын комиссын 02-р тогтоолыг үндэслэн Компанийн хувьцаа эзмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг. Хуралд саналын эрхтэй оролцогсдын 125895 ширхэг саналын эрх буюу 100 хувийн саналаар 2014 оны үйл ажиллагааны тайланд, 125895 ширхэг саналын эрх буюу 100 хувийн саналаар санхүүгийн тайланд хангалттай үнэлэлт өгч Балансыг баталсугай.

Хурлын дарга



Б.Мөнхбат





## “ХҮРД” /ХК/ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04-р сарын 10-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г

Г

Бизнес төлөвлөгөө батлах тухай

“Хүрд” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04 -р сарын 10-ны өдрийн хурлын Тооллогын комиссын 02-р тогтоолыг үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг. Хуралд саналын эрхтэй оролцогсдын 125895 ширхэг саналын эрх буюу 100 хувийн саналаар 2015 оны бизнес төлөвлөгөөг баталсугай.

Хурлын дарга

Б.Мөнхбат





Батлав: Ерөнхий захирал .....Б.Энхжаргал

**ЦСУ-ын "Хүрд" ХК-ийн 2015 оны бизнес төлөвлөгөө**

/ сая.төг/

№	Хэсэг нэгж	2014 оны төлөвлөгөө			2014 оны гүйцэтгэл			Төлөвлөгөөний биелэлт %	Амжилт %	2015 оны төлөвлөгөө									
		Ажилчиглээ		Ашиг	Ажилчиглээ		Ашиг			1 төг-т ногдох зардал	Дүн	Ажил үйлчилгээ				Ашиг			1 төг-т ногдох зардал
		Ажилчиглээ	Ашиг	Ажилчиглээ	Ашиг	Дүн	I					II	III	IV	Дүн	I	II	III	
1	Сантехник угсралт	4,120.00	288.40	2,880.80	408.63	0.86	0.70	1.42	3,100.0	100.0	1,050.0	1,150.0	800.0	248.0	8.0	84.0	92.0	64.0	0.92
2	Цахилгаан угсралт	610.00	48.80	331.34	70.15	0.79	0.54	1.44	413.0	0.0	100.0	240.0	73.0	33.0	0.0	8.0	19.2	5.8	0.92
	<b>БУА-ын дүн</b>	<b>4,730.00</b>	<b>337.20</b>	<b>3,212.14</b>	<b>478.78</b>	<b>0.85</b>	<b>0.68</b>	<b>1.42</b>	<b>3,513.0</b>	<b>100.0</b>	<b>1,150.0</b>	<b>1,390.0</b>	<b>873.0</b>	<b>281.0</b>	<b>8.0</b>	<b>92.0</b>	<b>111.2</b>	<b>69.8</b>	<b>0.92</b>
3	Төмөр хийц	128.00	11.52	211.76	53.10	0.75	1.65	4.61	140.0	0.0	40.0	62.0	38.0	12.6	0.0	3.6	5.6	3.4	0.91
4	Автобааз	86.00	5.16	150.40	-63.36	1.42	1.75	-12.28	86.0	0.0	30.0	40.0	16.0	5.2	0.0	1.8	2.4	1.0	0.94
5	Хангамж, аж ахуй	100.00	8.00	3,539.47	-69.94	1.02	35.39	-8.74	90.0	0.0	40.0	30.0	20.0	7.2	0.0	3.2	2.4	1.6	0.92
6	Бетон эдлэл	156.00	14.04	177.30	22.24	0.87	1.14	1.58	171.0	0.0	56.0	85.0	30.0	13.7	0.0	4.5	6.8	2.4	0.92
	<b>Дүн</b>	<b>470.00</b>	<b>38.72</b>	<b>4,078.94</b>	<b>-57.95</b>	<b>1.01</b>	<b>8.68</b>	<b>-1.50</b>	<b>487.0</b>	<b>0.0</b>	<b>166.0</b>	<b>217.0</b>	<b>104.0</b>	<b>38.6</b>	<b>0.0</b>	<b>13.1</b>	<b>17.2</b>	<b>8.4</b>	<b>0.92</b>
	<b>Бүгд дүн</b>	<b>5,200.00</b>	<b>375.92</b>	<b>7,291.08</b>	<b>420.82</b>	<b>0.93</b>	<b>4.68</b>	<b>-0.04</b>	<b>4,000.0</b>	<b>100.0</b>	<b>1,316.0</b>	<b>1,607.0</b>	<b>977.0</b>	<b>319.7</b>	<b>8.0</b>	<b>105.1</b>	<b>128.4</b>	<b>78.2</b>	<b>0.92</b>
7	Түрээс	100.00		99.20	99.20	0.00			112.0	28.0	28.0	28.0	28.0						
8	Бусад орлого			261.98	92.86				63.0	18.0	15.0	15.0	15.0						
9	Удирдлагын зардал				-203.46														
	<b>Нийт дүн</b>	<b>5,300.00</b>	<b>375.92</b>	<b>7,652.27</b>	<b>409.42</b>	<b>0.93</b>	<b>4.68</b>	<b>-0.04</b>	<b>4,175.0</b>	<b>146.0</b>	<b>1,359.0</b>	<b>1,650.0</b>	<b>1,020.0</b>	<b>319.7</b>	<b>8.0</b>	<b>105.1</b>	<b>128.4</b>	<b>78.2</b>	<b>0.92</b>

Ажлын албаны дарга .....Г.Гантуяа



## “ХҮРД” /ХК/ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04-р сарын 10-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г

Г

Орон сууц барих зөвшөөрөл олгох тухай

“Хүрд” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04 -р сарын 10-ны өдрийн хурлын Тооллогын комиссын 02-р тогтоолыг үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг. Хуралд саналын эрхтэй оролцогсдын 125895 ширхэг саналын эрх буюу 100 хувийн саналаар Баянзүрх дүүрэгт цэцэрлэг бүхий 15 давхар 98 айлын орон сууц барих зөвшөөрөл олгосугай.

Хоёр. Орон сууцыг төлөвлөсөн хугацаанд чанартай барьж, үр ашигтай ажиллахыг компанийн удирдлагад үүрэг болгосугай.

Хурлын дарга

Б.Мөнхбат







## “ХҮРД” /ХК/ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04-р сарын 10-ны өдөр

Дугаар ...04

Улаанбаатар хот

Г

Г

Удирдлагын зардлыг батлах тухай

“Хүрд” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04 -р сарын 10-ны өдрийн хурлын Тооллогын комиссын 02-р тогтоолыг үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг. Хуралд саналын эрхтэй оролцогсдын 125895 ширхэг саналын эрх буюу 100 хувийн саналаар 2015 оны удирдлагын зардлыг 249,5 сая төгрөгөөр баталсугай.

Хоёр. Батлагдсан удирдлагын зардлыг хэмнэж ажиллахыг компанийн удирдлагад үүрэг болгосугай.

Хурлын дарга

Б.Мөнхбат



"Хүрд" ХК-ийн ХЭХ-ын 2015 оны 04-р сарын  
10-ны өдрийн 04 тоот тогтоолын хавсралт

**ЦСУ-ын "Хүрд" ХК-ийн удирдлагын 2015 оны зардлын төсөв**

№	Зардлын төрөл	Зардлын тооцоо	Жилийн зардал /мян.төг/
<b>А.Цалин шимтгэл</b>			
1	Гүйцэтгэх захирал	1150,0x12 сар	13,800.0
2	Ерөнхий менежер	1050,0x12 сар	14,490.0
3	Ахлах менежер	950,0x12 сар	11,400.0
4	Захирлын туслах		
5	Ерөнхий ня-бо	750,0x2хүн x12 сар	18,000.0
6	Ажлын албаны дарга	950,0x12 сар	11,400.0
7	МХНААА-ны дарга	950,0x12 сар	11,400.0
8	Төслийн менежер	(800.0+750.0)x12 сар	18,600.0
	<b>Цалингийн дүн</b>		<b>99,090.0</b>
11	ЭМД,НД Шимтгэл	95940,0x12хувь	11,890.8
<b>Б.Аж ахуйн зардал</b>			
	Телефон,факс,и-мэйл,интернет	4x50,0x12+60x2x12 сар	3,840.0
13	Бичиг хэргийн зардал	110*2*12+8*5*12	3,120.0
14	Норм,норматив,хууль т/н эмхэтгэл	125,0 x12 сар	1,500.0
15	Цахилгааны зардал	12 сар x2000кВтх88	2,112.0
16	Халаалт /тоолуурын заалтаар/	20нэгж дулаан 29808.6т x7с	4,173.2
17	Цэвэр,бохир ус	10*1.5м3*235өдөр x425	1,498.1
18	Цэвэрлэгээ үйлчилгээ	100,0 x 12 сар	1,200.0
19	Томилолтын зардал /гадаад/	2 хүн x4удаа x2250000₮	18,000.0
20	Томилолтын зардал /дотоод/	6 хүн x 5 хоног x 2удаа x 12сар x 15000₮	10,800.0
21	Томилолтын байр, зочид буудал		8,900.0
22	Томилолтын унаа, онгоц, тээвэр	24 удаа x300.0+12x200.0	9,600.0
23	Албан унаа	2000 цаг x 1 машин x10000₮	20,000.0
24	Хүлээн авалтын зардал	500,0 x 12 сар	6,000.0
25	Үндсэн хөрөнгийн элэгдэл, газрын төлбөр	168.825 x12 сар	2,025.9
26	Тээврийн болон ҮХХ Татвар	1090тхт+1096үххт	2,186.0
27	Аж ахуйн зардал	200,0 x 12 сар	2,400.0
28	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн зардал	9хүн x 300,0 ₮	2,700.0
29	Удирдлагын урамшуулал		20,000.0
	Сургалт, хэлэлцээр,маркетингийн зардал		2,200.0
	<b>Нийт дүн</b>		<b>233,236.0</b>
31	ТУЗ-ийн зардал		<b>16,264.0</b>
	<b>Бүгд дүн</b>		<b>249,500.0</b>

**"Хүрд" ХК-ийн 2015 оны ТУЗ-ийн зардлын төсөв**

№	Зардлын төрөл	Зардлын тооцоо	Жилийн зардал /мян.төг/
1	ТУЗ-ийн гишүүдийн цалин	9 хүн x 60,0 x 12 сар	6480.0
2	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин	1 хүн x60,0 x 12 сар	720.0
	<b>Цалингийн дүн</b>		<b>7200.0</b>
3	ЭМД,НДШ	6000,0x12 хувь	864.0
4	Бичгийн хэрэгсэл,танилцах материал	10 хүн x 10,0 x12 сар	1200.0
5	Хурлын зардал		2500.0
6	ТУЗ-ийн гишүүдийн урамшуулал		4500.0
	<b>Дүн</b>		<b>16264.0</b>



## “ХҮРД” /ХК/ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04-р сарын 10-ны өдөр

Дугаар ...5...

Улаанбаатар хот

Г 7  
Гаражийн барилгыг ашиглалтаас хасах тухай

“Хүрд” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04 -р сарын 10-ны өдрийн хурлын Тооллогын комиссын 02-р тогтоолыг үндэслэн Компанийн хувьцаа эзмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг. Хуралд саналын эрхтэй оролцогсдын 125895 ширхэг саналын эрх буюу 100 хувийн саналаар 30 машины гаражийн 1524,4 мянган төгрөгийн өртөг бүхий барилгыг ашиглалтаас хасах ТУЗ-ийн тогтоолыг баталсугай.

Хоёр. Гаражийн барилгыг хөрөнгийн бүртгэлээс зохих журмын дагуу хасахыг компанийн гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

Хурлын дарга



Б.Мөнхбат





## “ХҮРД” /ХК/ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04-р сарын 10-ны өдөр

Дугаар ....6

Улаанбаатар хот

Г

Г

Сургалтын төлбөр олгосон ТУЗ-ийн  
тогтоолыг батлах тухай

“Хүрд” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04 -р сарын 10-ны өдрийн хурлын Тооллогын комиссын 02-р тогтоолыг үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг. Хуралд саналын эрхтэй оролцогсдын 125895 ширхэг саналын эрх буюу 100 хувийн саналаар компанийн боловсон хүчин бэлтгэх зардалд 150,0 сая төгрөг олгосон ТУЗ-ийн 2014 оны 02-р сарын 18-ны өдрийн 04 тоот тогтоолыг баталсугай.

Хурлын дарга

Б.Мөнхбат



## “ХҮРД” КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 02-р сарын 02-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г

Г

*ТУЗ-ийн ажиллагааны зардал олгох тухай*

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэр, ТУЗ-ийн гишүүдийн 100 хувийн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ :

Нэг."Хүрд" компанийн ТУЗ-ийн гишүүдийн ажиллагааны (утас, унаа, сурталчилгаа, судалгаа хийх г.м) зардалд 3000,0 мянган төгрөгийг хавсралтын дагуу олгосугай.

Хоёр. ТУЗ-ийн гишүүдийн ажиллагааны зардлыг 2015 оны 2-р сарын 05-ны дотор багтаан олгож, компанийн удирдлагын зардалд тооцохыг Санхүү, эдийн засгийн алба /Б.Сумъяа/д зөвшөөрсүгэй.

ТУЗ-ийн дарга

Б.Мөнхбат



“Хүрд” (ХК) компанийн ТУЗ-ийн  
2015 оны 02-р сарын 2-ны өдрийн  
03 тоот тогтоолын хавсралт №1

**ТУЗ-ийн ажиллагааны зардал**

№	ТУЗ-ийн гишүүдийн нэр	Албан тушаал	Олгох дүн
1	Б.Мөнхбат	ТУЗ-ийн дарга	300000,0
2	Б.Энхжаргал	ТУЗ-ийн гишүүн	250000,0
3	Б.Бат-Эрдэнэ	ТУЗ-ийн гишүүн	250000,0
4	Д.Мадгаа	ТУЗ-ийн гишүүн	250000,0
5	С.Эрдэнэчимэг	ТУЗ-ийн гишүүн	250000,0
6	Ц.Эрдэнэсүх	ТУЗ-ийн гишүүн	250000,0
7	Л.Оюунтогтох	ТУЗ-ийн гишүүн	300000,0
8	Д.Дашдорж	ТУЗ-ийн гишүүн	300000,0
9	Б.Эрдэнээ	ТУЗ-ийн гишүүн	300000,0
10	Г.Гантуяа	ТУЗ-ийн н.б дарга	250000,0
11	Б.Сумьяа	Ер.ня. бодогч	100000,0
12	О.Шинэхүү	Нягтлан бодогч	100000,0
13	Ж.Дүгэржав	Менежер	100000,0
	<b>Дүн /₮/</b>		<b>3000000,0</b>





## “ХҮРД” КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 03-р сарын 18-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Г

Г

*Ногдол ашиг олгох тухай*

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн санал, компанийн 2014 оны тайлан балансад хийсэн дүн шинжилгээ болон төлөвлөгөөний үзүүлэлтийн биелэлтийг үндэслэн ТОГТООХ НЬ :

Нэг."Хүрд" компанийн 2014 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 10 хувиар тооцож, нэгж хувьцаанд 273 төгрөг, нийт 36,927.6 мянган төгрөгийн Ногдол ашиг олгосугай.

Хоёр. Ногдол ашгийг бүртгэх өдөр (2015 оны 02-р сарын 16)-ийн жагсаалтын дагуу 2015 оны 2-р улиралд багтаан олгохыг Санхүү, эдийн засгийн алба /Б.Сумъяа/д зөвшөөрсүгэй.

ТУЗ-ийн дарга



Б.Мөнхбат

## "Хүрд" ХК-ийн 2014 оны Ногдол ашгийн тооцоо

2015.03.18

2014 оны баланс нь компанийн тухай хуулийн 47.1.1 заалтын дагуу ногдол ашиг хуваарилсны дараа компани төлбөрийн чадвартай байх нөхцөлийг, мөн өөрийн хөрөнгийн хэмжээ 47.1.2 заалтыг бүрэн хангаж байгаа тул 2014 онд ногдол ашиг хуваарилах боломжийг олгож байна.

### 2014 оны Ажил үйлчилгээ, ашгийн үзүүлэлт

№		Агуулга	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	Өөрчлөлт % /6/5/
0		1	2	3	4	5	6	7
1	Орлого	Үндсэн	2,731,401.3	2,706,959.7	3,961,121.3	3,303,301.1	7,291,093.8	220.7%
		Бусад	76,403.4	93,624.6	105,018.7	236,555.4	361,183.7	152.7%
	<b>Орлогын дүн</b>		<b>2,807,804.7</b>	<b>2,800,584.3</b>	<b>4,066,140.0</b>	<b>3,539,856.5</b>	<b>7,652,277.5</b>	<b>216.2%</b>
2	Зардал	Үндсэн	2,461,115.2	2,216,493.6	3,563,611.6	2,978,191.9	6,870,261.1	230.7%
		Бусад	76,072.4	82,923.6	131,093.8	146,987.5	372,589.3	253.5%
	<b>Зарлагын дүн</b>		<b>2,537,187.6</b>	<b>2,299,417.2</b>	<b>3,694,705.4</b>	<b>3,125,179.4</b>	<b>7,242,850.5</b>	<b>231.8%</b>
3	Ашиг	270,617.1	501,167.2	371,434.6	414,677.1	409,427.0	98.7%	
4	Татвар, бусад	72,642.8	50,116.7	73,104.2	72,072.4	40,942.7	56.8%	
5	Цэвэр ашиг	197,974.3	454,789.8	298,330.4	342,604.7	368,484.3	107.6%	
6	Цэвэр ашгийн хувь	7.2%	16.8%	7.5%	10.4%	5.1%		

Дээрх хүснэгтээс харахад 2014 оны цэвэр ашгийн үзүүлэлт 2013 оныхоос 7.6 хувиар өссөн, нийт борлуулалт 220.7% хувиар өссөн дүнтэй гарчээ.

### Нэгж хувьцаанд ногдох ашиг

№	Он	Цэвэр ашиг	Хувь	Нэгж хувьцаанд,	Хувьцааны тоо	Бүгд
1	2006 оны ногдол ашиг	59,440.4	14.0	65.0	135266	8,792,290.0
2	2007 оны ногдол ашиг	198,613.1	7.0	110.0	135266	14,879,260.0
3	2008 оны ногдол ашиг	56,288.7	12.0	50.0	135266	6,763,300.0
4	2009 оны ногдол ашиг	176,670.4	10.0	130.0	135266	17,584,580.0
5	2010 оны ногдол ашиг	197,974.3	9.4	138.0	135266	18,666,708.0
6	2011 оны ногдол ашиг	454,789.8	7.0	233.0	135266	31,516,978.0
7	2012 оны ногдол ашиг	298,330.4	9.0	198.0	135266	26,782,668.0
8	2013 оны ногдол ашиг	342,604.7	10.0	253.0	135266	34,222,298.0
8	2014 оны ногдол ашиг	368,484.3	10.0	273.0	135266	36,927,618.0

Цэвэр ашгийн үзүүлэлт өссөн дүнтэй байна. Сүүлийн 3 жилд ногдол ашигт олгосон цэвэр ашгийн дүнтэй харьцуулан 10 %-аар тооцон, 2014 оны нэгж хувьцаанд 273 төгрөг, нийт **36927.618** мянган төгрөгийн ногдол ашиг олгох боломжтойг ТУЗ-н хуралд танилцуулж байна.

**2014 оны цэвэр ашгийн 10% буюу 36927618 төг : 135266 ш = 273 ₮ ногдол ашиг нэгж хувьцаанд олгоно.**

Тооцсон: Ажлын албаны дарга..... Г.Гантуяа



## “ХҮРД” КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 04-р сарын 03-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Г 7  
Гаражийн барилгыг ашиглалтаас хасах тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэр, ТУЗ-ийн гишүүдийн 100 хувийн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ :

Нэг. Компанийн 30 машины гаражийн 1524,4 мянган төгрөгийн өртөг бүхий барилгыг акталж, ашиглалтаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Гаражийн барилгыг ашиглалтаас хасах тухай ТУЗ-ийн шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулахыг ТУЗ-ийн нарийн бичиг /Г.Гантуяа/-т даалгасугай.

ТУЗ-ийн дарга



Б.Мөнхбат





## "ХҮРД" (ХК) КОМПАНИ

Монгол улс, Улаанбаатар хот-46,  
Сүхбаатарын гудамж-71  
Утас: 320697, 325130 Факс: 976-11-320697  
E-mail: khurdcompany@gmail.com

2015-04-06 № 27  
Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХҮРД ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Б.МӨНХБАТ ТАНАА

### *Хүсэлт гаргах тухай*

Компанийн 30 машины гражийн барилга нь 1970 оны 03 дугаар сарын 15-нд ашиглалтанд орж 45 жил ашиглагдаж одоо засвар үйлчилгээ хийж цаашид ашиглагдах ямар ч боломжгүй болж байна.

Уг барилга нь 3-р баазын хувьчлалын 1991 оны дахин үнэлгээгээр 3010,0 мянган төгрөгөөр үнэлэгдсэн хуримтлагдсан элэгдэл нь 1485,6 мянган төгрөг одоо үлдэгдэл өртөг нь 1524,4 мянган төгрөг байна.

Иймд уг гражийн барилгыг актлаж данснаас хасах талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж зохих шийдвэр гаргаж өгнө үү?

*Жүч: Гражийн барилгын фото зургийг хавсаргав.*

Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Хүндэтгэсэн.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ.....Б.ЭНХЖАРГАЛ

